



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ДЭД САЙД С.ЗУЛПХАР

АГУУЛГА

1

ЯДУУРАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3

2023 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

4


ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН
АРГА ХЭМЖЭЭ, ШИЙДЭЛ

ЯДУУРАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЯДУУРЛЫН ТҮВШИН

Ядуурлын түвшин 2010-2014 онд 38.8-21.6 хувь болж тогтвортой буурч байсан боловч 2014-2016 онд 8.0 пунктээр огцом өссөн. Харин 2016 оноос ядуурлын түвшний энэхүү өндөр өсөлт зогсож, бага багаар буурч байна.

ЯДУУРЛЫН ТҮВШИН, ЯДУУ ХҮН АМЫН ТОО




КОВИД-19 цар тахал 2020 онд гарснаар ядуурал буурах явцыг удаашруулсан байна. Хэрэв цар тахал гараагүй бол ядуурлын түвшин 2020 онд 24.3 хувьд хүрэх байжээ

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЯДУУРАЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ (%)



НИЙГМИЙН ХАЛАМЖ БОЛОН НИЙТЛЭГ МӨНГӨН ТУСЛАМЖИЙН ЗАРЦУУЛАЛТ /2000-2021 он, тэрбум төгрөг/

Өсөлт, өөрчлөлт, өнөөгийн байдал
 Өсөлт, өөрчлөлт, өнөөгийн байдал
 Өсөлт, өөрчлөлт, өнөөгийн байдал



Ихэнх улс ДНБ-ий 1-2 хувийг халамжид зарцуулж байна.

2022 онд батлагдсан төсөв
482.9 тэрбум төгрөг

НХ-ийн зардал ДНБ-ний 2000 онд 2.1%, 2018 онд 2.1%, 2019 онд 2.0%, 2020 онд 4.3%, 2021 онд 7.0%

НХ-ийн зардал Нэгдсэн төсвийн 2000 онд 2.1%, 2018 онд 6.6%, 2019 онд 5.9%, 2020 онд 11.5%, 2021 онд 19.24%



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВТАМЖ

مەھەممەد نەبىيە كۆرۈنۈشى

		Багц үйлчилгээ	Сард	Улиралд	Жилд	Жилээс дээш хугацаанд	Тухай бүр	Нийт	
1	Нийгмийн эмзэг бүлэгт /58/	Нийгмийн халамжийн тэтгэвэр	+					5	
2		Нийгмийн халамжийн тэтгэмж	+	+				10	
3		Нийгмийн халамжийн үйлчилгээ			+			13	
4		Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	+				+	3	
5		Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт					+		11
6		Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт				+			16
7	Нийтлэг мөнгөн тусламж /14/	Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт					+	+	6
8		Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	+						4
9		Насны хишиг				+			1
10		Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж				+			1
11		Цаатан иргэнд олгох тэтгэмж	+						1
12		Хүүхдийн мөнгөн тэтгэмж	+						1
Нийт			21	4	23	5	19	72	

15.5 МЯНГАН ӨРХИЙН **87.8** МЯНГА ГАРУЙ ИРГЭНИЙГ ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭС ХАССАН /2022 оны 8-р сарын байдлаар/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг шинэчлэв.



ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧИГТ ХАМРАГДАЖ БУЙ ИРГЭД /ХҮН АМЫН БҮЛГЭЭР/

- Ахмад настан – 6.4 мянга
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн – 10.7 мянга
- 0-18 насны хүүхэд – 68.6 мянга
- Өрх толгойлсон – 4.5 мянга

➤ Журмын шинэчлэлээр

01

- Хамрагдах хугацаа **2** жил
- **200**-аас дээш малтай өрх
- **2** байшинтай өрх
- **2** машинтай өрх
- Хөдөлмөрийн насны иргэнийг **2** буюу түүнээс дээш удаагийн тохирсон **ажлын байранд зуучлахад** татгалзсан тохиолдолд дэмжлэгээс хасах.

02

Зөвхөн гэрээт дэлгүүрээр үйлчлүүлдэг байсныг НӨАТ-ын баримт хэвлэдэг хүнсний дэлгүүр, томоохон супермаркет, зах, бөөний төвөөр үйлчлүүлдэг болгов.


03

Хүнсний эрхийн бичигт хамрагддаг хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэх нөхцөл тавьж, 4462 иргэнийг ургац хураалтын ажилд хамруулав.


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

ДНБ-д хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын эзлэх хувь



Төсвийн нийт зарлагад хөдөлмөр эрхлэлтийн салбарын зарлагын эзлэх хувь



АЖИЛГҮЙ ИРГЭД, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН



2.9%

Нийт хүн амд
эзлэх хувь




99.8 мянга

Ажилгүй иргэн
/2021 он/


Ажилгүй байгаа иргэдийн шалтгаан, хамгийн их хувь эзэлж байгаа 10 шалтгаан

1	Ажил хайгаад олдохгүй байгаа	39.1%
2	Үүсээд байгаа цар тахлын улмаас	14.9%
3	Мэргэжил, дадлага туршлага байхгүй	8.4%
4	Мэргэжилд тохирох ажил олдохгүй	6.9%
5	Жирэмсэн/хүүхэд асарсан	5.0%
6	Улирлын чанартай ажил хийдэг болохоор	4.5%
7	Тухайн жилд сургууль төгссөн	3.5%
8	Цалин бага учраас	2.8%
9	Өвчтөн, өндөр настан асарсан	1.9%
10	Цомхтголд орсон	1.6%

АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, оноор



Ажилгүйдлийн түвшин, 2021 он, бүсээр



Ажилгүй иргэд, бүсээр

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ БА ХОМСДОЛ, 2021 ОН

مەھسۇبىيەت، مەھسۇبىيەت، مەھسۇبىيەت


ХУГАЦАА



АЖЛЫН БАЙРНЫ ХЭЛБЭР



АЖЛЫН БАЙРНЫ ХЭЛБЭР




19.1%

Нийт **57.1** мянган ААНБ-ын **10.9** мянга нь ажиллах хүчний хомсдолд орсон байна.




24.4% хувь нь цар тахлын нөлөөгөөр ажиллах хүчний хомсдолд орсон байна.





ДУНДАЖ ЦАЛИН



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, хүйсээр



Медиан цалин, мянган төгрөг




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр



Хамгийн бага: 5 хөтөлбөр, 2012, 2015, 2021 он
 Хамгийн их: 10 хөтөлбөр, 33 арга хэмжээ, 2014 он
 Хамрах хүрээ: 27 зорилтот бүлэг
 Нийт: 64 төрлийн арга хэмжээ

Хөтөлбөр батлах, хэрэгжүүлэх процесс



6
чиглэл

Ажилд зуучлал

Санхүүгийн
дэмжлэг

Сургалт

Гарааны бизнес

Нийтийг хамарсан
ажил

Бусад арга хэмжээ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

2022 оны 9-р сарын байдлаар

**Хэрэгжилт
53.4%**



43.6 мянга
Хамрагдсан
иргэд

**Батлагдсан төсөв
59.7 тэрбум төгрөг**




31.9 ТЭРБУМ
Зарцуулсан
хөрөнгө



**23.5 МЯНГАН
АЖЛЫН БАЙР
БИЙ БОЛСОН**

Байнгын 4.8 мянга
Түр 14.5 мянга
Цагийн 4.2 мянга



ОРОЛЦОО ТӨСЛИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ




СҮҮЛИЙН 3 САР
АЖИЛ, ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЭГҮЙ

ИХ ДЭЭД
СУРГУУЛЬ, МСҮТ
СУРАЛЦААГҮЙ

18-34 НАСНЫ
ЗАЛУУЧУУД

ҮР ДҮН



Мэргэжлийн ажил эсэх:

- 44.1% - Мэргэжлийн дагуу
- 55.9% - Мэргэжлийн бус

СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

01

Монгол Улсын нийт хүн амын 29.8 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 43.9 хувийг бүрдүүлдэг 15-34 насны залуучууд эзэлдэг.

02

2021 оны байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8.1 хувь байгаа хэдий ч 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 17.9 хувь байна.

03


2021 оны байдлаар нийт 99780 ажилгүй хүн байгаагийн 52.4 хувь буюу 52354 нь 15-34 насны залуучууд байна.

Эх сурвалж: ҮСХ-ны Ажиллах хүчний судалгаа – 2021 он

Сургалтаас хамгийн их ач холбогдолтой байсан хичээл



Оролцогчдын төслийн талаарх сэтгэл ханамж



Оролцогчдын
30.1%
хүнсний эрхийн
бичигт хамрагддаг
байсан.



2389 2021 ОНЫ
ОРОЛЦОГЧИД

1233 2022 ОНЫ
ОРОЛЦОГЧИД


37.5% 62.5%




ҮР НӨЛӨӨ

ХӨДӨЛМӨР ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТ ЭРЭЛТ, ЭЗҮАС-аар, 2015-2024* он


Худалдаа, засвар үйлчилгээ




Барилга




Боловсруулах үйлдвэрлэл




Зочид буудал, байр хоол




Эрүүл мэнд




Тээвэр агуулах




Боловсрол




Үйчилгээний бусад




Мэргэжлийн болон ШҮ




Уул уурхай




Санхүүгийн үйл ажиллагаа




Мэдээлэл холбоо




Үл хөдлөх хөрөнгө



Хөдөө аж ахуй






НИЙТ ЭРЭЛТ



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2023-2024 ОНЫ ТААМАГЛАЛ /СИСТЕМ ДИНАМИК ЗАГВАР БОЛОН CGE/

Загвар-1: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550.0 мянган төгрөгт хүргэхэд хийсэн систем динамик загварын симуляци, түүний үр дүн



Нийгмийн даатгалын сангийн орлого **290.0** орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Энэ симуляцийн үр дүнд ажил эрхлэлт нэмэгдэнэ гэсэн тооцоо гарсан.

$$\left\{ \begin{array}{l} f = -49.577 + 0.016x_1 + 0.503x_2 - 0.023x_3 - 0.061x_4 + 2.026x_5 \rightarrow \max \\ 16000 \leq x_1 \leq 20000 \\ 1335 \leq x_2 \leq 1600 \\ x_3 \geq 19116 \\ x_4 = 500 \\ 0 \leq x_5 \leq 9 \end{array} \right.$$

Шийдвэр гаргалтад нөлөөлсөн байдал

"Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоол 2023.01.01-ний өдрөөс Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550.000₮ байхаар шийдвэрлэсэн.

2023 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠬᠠᠯᠠᠮᠵᠢᠶᠢᠨ ᠰᠠᠩᠭᠢᠨ 2023 ᠣᠨᠤ ᠲᠥᠰᠪᠢᠶᠢᠨ ᠰᠠᠨᠠᠯ

д/д	Халамжийн хөтөлбөрүүд	2022 он тодотгол төсөв /тэрбум төг/	2023 он Хязгаар /тэрбум төг/	2023 он УИХ-д өргөн барьсан /тэрбум төг/
1	Халамжийн тэтгэвэр	129.5	243.9	243.9
2	Асаргааны тэтгэмж	59.4	59.4	59.4
3	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	41.4	41.4	41.4
4	Цалинтай ээж	123.0	123.0	123.0
5	Ахмад настнуудад үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэл	26.0	26.0	26.0
6	ХБИ-д үзүүлэх хөнгөлөлт, тусламж	9.8	9.8	9.8
7	Насны хишиг	25.4	25.4	25.4
8	Эхийн алдар одон	31.3	31.3	31.3
9	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	23.3	23.3	23.3
10	Жирэмсэн эхийн тэтгэмж	11.3	11.3	11.3
11	Асрамжийн үйлчилгээ	0.5	0.5	0.5
12	Хүүхдийн мөнгөн тэтгэмж			1,394.6
13	Халамжийн сангийн үйл ажиллагааны зардал	2.0	2.0	1.3
Нийт дүн		482.9	597.4	1,991.4

ХӨДӨЛМӨР, ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

ᠬᠥᠳᠥᠯᠮᠥᠷ, ᠡᠷᠬᠡᠯᠡᠯᠲᠡᠢᠭᠢᠭᠦᠳᠡᠮᠵᠢᠬᠢ ᠰᠠᠩᠭᠢᠨ 2023 ᠣᠨᠢ ᠲᠥᠰᠪᠢᠶᠢᠨ ᠰᠠᠨᠠᠯ

№	Төсвийн ангиллын нэр (Шинэ)	2022 оны батлагдсан төсөв	2023 оны төсвийн төсөл
1	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	1,670,000,000.0	1,847,028,000.0
2	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	2,122,820,000.0	2,057,185,000.0
3	Санхүүгийн дэмжлэг	32,405,728,000.0	33,011,784,000.0
4	ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	11,768,600,000.0	11,209,858,000.0
5	Түр ажлын байрыг дэмжих	9,739,600,000.0	10,231,700,000.0
6	ЗГ,ХЭҮЗ-ийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл	14,499,010,000.0	20,738,900,900.0
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	6,222,121,900.0	6,280,186,000.0
8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад арга хэмжээ	25,000,000,000.0	5,000,000,000.0
НИЙТ		103,427,879,900.0	90,376,641,900.0

УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН
90.4 тэрбум төгрөг

ЭХ ҮҮСВЭРИЙН ХУВЬД:

- Урьд оны үлдэгдлээс – **45.9 тэрбум төгрөг**
- Зээлийн эргэн төлөлтөөс – **8.0 тэрбум төгрөг**
- Гадаад улс, ОУБ-ын зээл, тусламж – **5.0 тэрбум төгрөг**
- Гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого – **28.1 тэрбум төгрөг**
- ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлого – **3.4 тэрбум төгрөг**

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, ШИЙДЭЛ

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. ОРОН НУТАГ ОНЦЛОГТОО ТОХИРСОН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлогт тохирсон байдлаар хэрэгжүүлнэ.

(2023 оноос хэрэгжүүлнэ)

ҮР ДҮН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төлөвлөлт боловсронгуй болж, орон нутгийн онцлогт тохирсон ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Бий болох ажлын байр 53.8 мянга. Үүнээс:

- Байнгын – 16.3 мянга
- Түр – 30.6 мянга
- Цагийн – 6.7 мянга

Хадгалах ажлын байр 24.1 мянга

2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙНЭ

Ажил хайгч иргэнд хувь хүний чадавхийг нь үнэлэх, хөдөлмөр эрхлэх төлөвлөгөө боловсруулах, ажилд зуучлах, аж ахуй эрхлэх цогц дэмжлэг үзүүлнэ.

(2023 оноос хэрэгжүүлнэ)

ҮР ДҮН

Улсын хэмжээнд **50.0** мянган ажил хайгч иргэнд хөдөлмөр эрхлэлтийн үнэлгээ хийж, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг боловсруулж, ажлын байртай болтол хамтарч ажиллана.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ БОЛОН БАГА ХҮҮТЭЙ ЗЭЭЛ ОЛГОНО

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил аж ахуй эрхлэгчдэд:
 - **50.0** хүртэл сая төгрөгийн хөнгөлттэй зээл,
 - **10.0** хүртэл сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг,
 - **1.0** сая хүртэл төгрөгийн богино хугацааны **финтек** зээл олгоно.

(2022 оны 11 дүгээр сараас эхлүүлнэ)

ҮР ДҮН

- Банкаар дамжуулан **20.0 тэрбум** төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1400 орчим хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил аж ахуй эрхлэгчдэд олгож, 3500 орчим байнгын ажлын байр бий болгно.
- Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар дамжуулан **33.0 тэрбум** төгрөгийн хүүгүй, барьцаагүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 3500 орчим хувиараа хөдөлмөр эрхлэгч, мал аж ахуй эрхлэгчид олгож, 5200 орчим байнгын ажлын байрыг бий болгож, хадгална.
- Гар утасны аппликейшнээр нийт **3.6 тэрбум** төгрөгийн хөрөнгөөр богино хугацааны 1.0 сая хүртэл төгрөгийн зээлийг Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгуудад туршилтаар хэрэгжүүлж эхэлнэ. Улмаар албан бус /өдрийн зээл/ зээлийн үйл ажиллагаа багасна.

4. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН E-JOB ПЛАТФОРМ НЭВТРҮҮЛНЭ

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн систем бүхий “E-JOB” платформыг нэвтрүүлж, ажил хайгч, ажил олгогчийг шууд холбох цахим хөдөлмөрийн бирж ажиллуулна.

(2022 оны 11 дүгээр сараас нэвтрүүлнэ)

ҮР ДҮН

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ цахимжсан байна.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5. ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ “ОРОЛЦОО” ТӨСЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ

Зөв хандлага, зөөлөн ур чадвар олгох “Оролцоо” хөтөлбөрт залуусыг хамруулан хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэж, ажилд зуучилна.

Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийг 1 жилээс дээш хугацаагаар ажлын байраар хангах аж ахуйн нэгжид цалингийн зардлын дэмжлэг үзүүлнэ.

(2023 оноос хэрэгжүүлнэ)

ҮР ДҮН

Хөтөлбөрт 5000 залуучуудыг хамруулж, тэдний 80 хувийг ажил, орлоготой болгосон байна.

Их, дээд сургууль, МСҮТ төгсөгч 5000 залуучуудыг байнгын ажлын байранд зуучилсан байна.

6. АЖИЛ ОЛГОГЧИЙГ ДЭМЖИНЭ

Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийг 1 жилээс дээш хугацаагаар ажлын байраар хангах аж ахуйн нэгжид цалингийн зардлын дэмжлэг үзүүлнэ.

(2023 оноос хэрэгжүүлнэ)

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Эдийн засгийн тэргүүлэх салбар чиглэлд болон орон нутагт ажиллах **5.0** мянган залуучуудад Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцэхүйц цалин, урамшууллыг **3-6 сарын хугацаанд** ажил олгогчид нь олгоно.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

7. АЛБАН САЛБАРТ ШИЛЖҮҮЛНЭ

Албан бус салбарт ажил эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, ур чадвар олгох, албан салбарт шилжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

(2023 оноос хэрэгжүүлнэ)

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Аймаг, сум, дүүрэг-хороодын Хөдөлмөрийн байгууллагын үйл ажиллагааг нягт уялдуулан төрийн цахим өгөгдөлд суурилан, бүртгэлжүүлэх, тэдгээрт хэрэгцээтэй богино хугацааны ур чадвар олгох сургалт зохион байгуулах, өмнөх, мэдлэг ур чадврын үнэлгээ хийж, баталгаажуулах.

8. “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”, ТОМООХОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭД ШААРДАГДАХ УР ЧАДВАРТАЙ АЖИЛТНЫГ БОГИНО ХУГАЦААНД БЭЛТГЭНЭ.

Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн салбарууд дахь ажлын байран дээрх ур чадварын сургалтын тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.

(2023 оноос хэрэгжүүлнэ)

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Зорилтот бүлгийн иргэд болон ажиллах хүчнээс гадуурх хүн амын хөдөлмөр эрхлэх ур чадварт оношлогоо хийж, хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын үнэлгээнд суурилан, ажил олгогчийн эрэлтэд нийцсэн сургалтын хөтөлбөрийн хүрээнд ажлын байран дээр дадлагажуулна.

Тогтвортой хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор менторын үйлчилгээ үзүүлнэ. Салбар бүрд менторын үйлчилгээ үзүүлэх зөвлөхүүдийн мэдээллийн сан бүрдүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн механизм бүрдүүлэх, урамшуулал олгох.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО

- ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 181 болон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88 конвенцид нийцүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.
- Хөдөлмөр эрхлэлтийн төрийн, олон нийтийн, хувийн байгууллагын чиг үүрэг, хүний нөөцийн оновчтой тогтолцоог бий болгоно.
- Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

10. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ОНОВЧТОЙ УДИРДАХ, САЛБАР ДУНДЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАНА.

Хөдөлмөрийн зах зээлийн ойрын, дунд, урт хугацааны эрэлт, нийлүүлэлтийг системийн **динамик загварыг** ашиглан оновчтой тодорхойлж, салбар дундын үйл ажиллагааны уялдаатайгаар мэргэжилтэй ажиллах хүчний нөөцийг бэлтгэнэ.

ҮР ДҮН

- Эдийн засгийн тэргүүлэх салбаруудад шаардагдах хүний нөөц, боловсон хүчнийг бэлтгэх бодлогыг тодорхойлоход чиглэсэн бодлогын зөвлөмжийг салбар яамдад хүргүүлнэ.
- Их өгөгдөлд тулгуурласан нийгэм, эдийн засгийн үр нөлөөний талаарх тооцооллыг боловсруулж, бодлого төлөвлөлтөд ашиглана.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

11. ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАНА

Хөдөлмөрийн тухай хуулийн сургалт, сурталчилгаа, түгээн дэлгэрүүлэх, таниулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр Хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудтай хамтран ажиллана.

“144 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт”-ийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт тавих.

ОНЦЛОХ ЗОХИЦУУЛАЛТ

- ❑ Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй.
- ❑ Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- ❑ Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч түүнд гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжит арга хэмжээг авна.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО

12. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга /дагалдах 14 хуулийн төсөл/-ын төслийн үзэл баримтлал:

Зорилтот
бүлэгт
чиглүүлнэ

Халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгож нэгтгэн багцалсанаар **ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ХАМГИЙН ИХ ШААРДЛАГАТАЙ** зорилтот бүлэгт чиглэсэн

/72->40/

Бэлэн мөнгөний бус үйлчилгээг нэмнэ

Нийт хөтөлбөрийн 90 гаруй хувь нь бэлэн мөнгөний хөтөлбөр байгааг өөрчилж зорилтот өрх, иргэдийг хөгжүүлэх, чадавхижуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх **ШИНЭ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** бий болсон

Хөдөлмөр эрхлэлттэй холбоно

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай халамж хүртэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах **НӨХЦӨЛТЭЙГӨӨР** халамжид хамрагдана

Халамжийн тогтолцоог сайжруулна

Халамжийн байгууллага, ажилтан, оролцогч талын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн, нийгмийн ажилтан **НИЙГМИЙН АЖЛЫН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн

Орон нутгийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ

Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан өөрийн нутаг дэвсгэрийн ядуурал ихтэй бүсээс **ЖИЛ БҮР ТОДОРХОЙ ТООНЫ ӨРХИЙГ ЯДУУРЛААС ГАРГАХ** талаар Засгийн газрын өмнө үүрэг хүлээдэг болно

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

مەھەممەد سەئید ھەسەن



13. Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг, ядуурлын түвшингээс доогуур орлоготой **1520** өрхийг эхний ээлжинд ядуурлаас гаргана.

/2022 оны 11 дүгээр сараас эхлүүлнэ/

“ҮР ДҮН”

Халамжийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн хөдөлмөр эрхлэх боломжтой гишүүнийг ажил, орлоготой болгох, ядуурлаас гаргах үндэсний аргачлал бий болно.

/Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг/



БАЯРЛАЛАА

ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ ХАМТДАА



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 4-р хороо,
Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160

- ✉ info@mlsp.gov.mn
- ☎ + (976) 51-261553 /Бичиг хэрэг/
- ☎ + (976) 51-266235 /Хэвлэлийн төлөөлөгч/
- ☎ + (976) 11-328634 /Факс/